

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVII (597)

DOI: 10.22353/ms20234707

МОНГОЛ ХЭЛНИЙ DARAҮ-А ХЭМЭЭХ ҮГИЙН ӨГҮҮЛБЭР ДЭХ
УТГА, ҮҮРЭГ, ХЭРЭГЛЭЭ

Ч.Бямбаханд
Н.Ундармаа

Товч хураангуй: Орчин цагийн монгол хэлэнд *daraү-а* гэх үгийн утга нь нэг талаас ерөнхий ойлгомжтой мэт боловч нөгөө талаас найруулгын алдааны шинжилгээ (error analysis) хийхэд найруулгын алдаа үүсэх тохиолдол байдаг тул цаашид хэрэглээний хэл шинжлэлийн талаас нарийвчлан судлах хэрэгцээ урган гарч байна. Иймд монгол хэлний *daraү-а* гэх үгийг яриа ба бичгийн хэлэнд бүтээвэр зүй, өгүүлбэр зүйн завсрын түвшинд хэрхэн оновчтой ашиглахыг тайлбарлах зорилготой. Үүний тулд өгүүлбэрт цаг заасан байц гишүүний үүргээр дангаар ба хорших, давтах хэлбэрээр тохиолддог *daraү-а* гэх үгийг өгүүлбэрт цаг заасан байц гишүүн, задлаг аргаар нийлмэл өгүүлбэрийн холбоосын үүргээр хэрхэн тохиолдож байгааг задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргаар судлав. Монгол хэлний *daraү-а* гэх үг нь өгүүлбэрт цагийн байц гишүүн болохын зэрэгцээ нийлмэл өгүүлбэрт цагийн байц гишүүн өгүүлбэрийн бүтэц дотор нийлэг болон задлаг бүтцээр хэрхэн илэрч байгаа зүй тогтлыг тодорхойлж, тайлбарлахын зэрэгцээ L1 болон L2 хэл заах арга, судалгаанд ашиглах практик ач холбогдолтой юм.

Түлхүүр үг: орон цагийн нэр, цагийн нэр, байц гишүүн, цагийн байц гишүүн, цагийн байц гишүүн өгүүлбэр

Хүн төрөлхтөн юмс үзэгдлийг танин мэдэх нь хязгааргүй боловч, Людвиг Витгенштейн “Миний хэлний хязгаар бол миний сэтгэлгээний хязгаар” (Die Grenzen meiner Sprache bedeuten die Grenzen meiner Welt) гэж хэлснээр өгүүлэгч хэлэхүйн урсгалд төгс санааг илэрхийлэхдээ хэлний үзэгдэл нь хэрхэн хувьсан өөрчлөгдөж буйг төдий л нарийн ажигладаггүй боловч энэхүү хувьслыг хэлний зүй тогтлоор тогтолцоотой илэрхийлдэг байна. Тийм учраас байгаль, нийгэм, технологийн шинжлэх ухаанд дараалал гэх ойлголт нь янз бүрийн ухагдахууныг илэрхийлдэг төдийгүй дэлхийн олон хэлэнд мэдлэг, мэдээллийг дамжуулахдаа юмс үзэгдлийн харьцааг орон зай, цаг хугацааны дараалалтай хэрхэн холбож ойлгохыг хэл, соёлын онцлогтой уялдуулан олон зууны туршид өргөн хүрээнд тайлбарлаж ирсэн төдийгүй хэл шинжлэлийн эрдэмтэд ч өөрсдийн үзэл онолыг хөгжүүлсээр байна.

Иймд хэлний хийсвэр нэгжийг хэлний тусламжтайгаар хүмүүс дарааллын онол (queueing theory) -ын загвараар орон зай, цаг хугацааны дараалалд оруулан хэрхэн илэрхийлж байгаа нь ертөнц дэх зүй тогтлын ойлголттой холбоотой тул хэл зүйн хийсвэр харьцаа давамгайлсан илтгэх монгол хэлний *daray-ā* хэмээх үгийн зарим онцлогийг дурдъя.

Монгол хэлний *daray-ā* хэмээх үгийг Александр Бобровников “*orui, qojid*” хэмээх үг нь цаг хугацаа, *darayār* гэх үг нь дэс дараалал (1835:77) заана гэсэн бол Б.Я.Владимирцов “*qoyin-a, xoyin-a, xóēnō дараа*” (1929:87) гэж харин Г.И.Рамстедт *darān* (дараа нь), *darādh* (дараад нь), *daruga-ldu-* (дахин давтах, нэг эгнээнд байх), *darān daruyār irtsyāw* гэхийг “дараа дараагаар цагтаа ирэх”, (*darān*) *marān* “дараа мараа нь” (1935:77) гэсэн бол Г.Д. Санжеев, М.Н. Орловская, З.В. Шевернина нар *daray- ā* [**dara-γ-a* < [**dara-γa*] (2015:172), Б.Х. Тодаева язгуур дайвар үгэнд үл хувилах идэвхгүй язгуураас үүсдэг “*orui, ürgelji, qā-yā, erte, odu-ā*” зэрэг үгсийг багтааж мөн цагийн утгат дайвар үгэнд *daray-ā* (1951:158) гэх үгийг харин Ш.Лувсанвандан, гүйцэд ялгаллагдах нэр үгэнд нэр үг, тэмдэг үг, төлөөний үг, тооны үгсийг багтааж, хагас ялгаллагдах үгэнд *qojim* (1939:75) гэх үгийг багтааж, улмаар дутмаг нэрэнд *qojim* гэх үгийг орон цаг, зүг чиг заасан бүлэгт (1951:116), Ц.Жанчивдорж, Б.Рагчаа нар үүсмэл дайвар үгэнд мөхсөн язгууртай тийн ялгалаар хагас ялгаллагдах үүсмэл дайвар үгэнд *qojim* гэх үгийг багтааж, утгаар нь цагийн дайвар үгэнд *daray-ā, qojim* (1967:33) гэх үгсийг багтаажээ. Орчин цагийн монгол хэл номд *qojim, darui, orui* (сүүлдэх, хоцрох гэсэн утгатай) (1997:243) гэх үгийг зөвхөн цаг заасан үг гэж үзсэн бол Д.Цэрэнпил, Р.Кулман нар *daray-ā, qojim, ayār, qōyisi-da* зэрэг үгийг зөвхөн цаг заасан утгатай үг (2008:221), харин Ц.Өнөрбаян утга зүйн шинжээр нь цагийн нэрэнд *qojim, daray-ā, orui, marāsi, darui, möddü/ken* (2004:223) зэрэг үгсийг багтааж улмаар М.Базаррагчаа *marāsi, nögügēdür, darui, qojim, daray-ā, orui, möddü/ken* гэх үгийг цагийн нэр (2005:191) гэж тус тус үзжээ.

Монгол хэлний *daray-ā* гэх үгийн утгыг хэрэглээний хэл шинжлэлийн талаас судлах нь олон нийтийн хэлний боловсролд практик ач холбогдолтой төдийгүй үгийн сангийн хувьд явцуу ч хэл зүйн хэрэглээнд түгээмэл ашиглагддаг. “Монгол хэлний тайлбар толь”-д дараа I (хойно, хожим, сүүлд; хожим болох; байн байн; дэс, зэрэг, эрэмбэ) дараа II. тээр, саад (2011:159) гэж нэгдүгээр утга нь дайвар үг, хоёрдугаар утга нь нэр үг гэж үзжээ.

Германы Лайпцигийн их сургуулийн монгол хэлний корпусын нийт 377892 өгүүлбэрт *daray-ā* гэх үг 5749 тохиолдож, 81 дүгээрт эрэмбэлэгдэж, 4 дүгээр түвшин (*corpora.uni-leipzig.de*) -д байгаа өндөр давтамжтай үг болохыг дээрх тоон үзүүлэлт илтгэнэ. Үүнээс үүдэн орчин цагийн монгол хэлний *daray-ā* хэмээх үгийн утгыг хэлний хэрэглээний жишээнээс тодруулав.

I. *daray-ā* хэмээх үгийн утга

1.а. дан үгээр илрэх нь

Монгол хэлний *daray-ā* хэмээх үг нь сүүлийн “*ā*”-д өргөлт оногдож өмнөх “*a*” эгшигтэй нийлж урт “*ā*” эгшиг үүсэж, идэвхгүй язгуурт “*-γ-ā*” дагавар залган бүтэж, нэрийн тийн ялгалаар хувиран, *daray-ā, daray-ā-la* (V)-l (*N_{sub.}*), *daray-ā-la*

(V)-qu (V), dara-ā-ki ($N_{\text{adj.}}$), daray-ā-či гэх мэт бүтэцтэй тохиолдохын зэрэгцээ онцлон ялгах утгатай хамаатуулахын “нь” нөхцөлөөр хэлбэрждэг байна.

Ярианы ба бичгийн хэлнээ түгээмэл тохиолдох daray-ā хэмээх үг нь орчин цагийн монгол хэлэнд дараа I (daray-ā), дараа II (daruy-ā) гэхэд дуудлага бичлэг адил боловч утгын хувьд харилцан адилгүй. Энэ нь L1 болон L2 хэлний сургалт, судалгаанд найруулгын алдаа үүсгэж байгаа тул утгын ялгаа, хэлбэржих байдал, хувиргалтын онцлогийг нарийвчлан тайлбарлах хэрэгцээ урган гарч байна. Тухайлбал, daray-ā I

а.1. дэс дараа нь ($N_{\text{sub.}}^{\text{nomi.}}$), дараа-г-ийн нь ($N_{\text{sub.}}^{\text{gen.}}$), дэс дараа-г-ий нь ($N_{\text{sub.}}^{\text{accu.}}$), дэс дараа-тай нь ($N_{\text{sub.}}^{\text{comi.}}$), дараахан шиг/даруйхан шиг илгээх ($N_{\text{sub.}}^{\text{comp.}}$)

а.2. дараад нь ($N_{\text{sub.}}^{\text{dat.loc.}}$), дэс дараа-г-аас ажиглах ($N_{\text{sub.}}^{\text{abl.}}$), дараа-ч-аар ирье ($N_{\text{sub.}}^{\text{instr.}}$)

гэхэд гурваас дээш зүйлийг харьцуулж дараалуулах, дэс дараатай, алхам алхмаар хийх дарааллыг зүй тогтолд оруулж нэр үгийн шинж давамгайлахын зэрэгцээ дэс дараа, зэрэг дэв, эрэмбэ дарааллыг заана.

б. uday-ā daray-ā, uday-ā darayālan, uday-ā daray-ā yin, uday-ā daray-ā yiar, uday-ā daray-ā-či-yin гэхэд тухайн үйлийг тогтмол хугацаанд дахин дахин, байнга тасралтгүй хийх давтамж заана.

в. “Дараа өртөө” дууны үгэнд “дараа” гэх үг нь хамжсан тодотголын үүргээр орж орны утга илтгэнэ. Гэвч энэ нь гадаад хэлний орчуулгын нөлөөгөөр үндсээрээ бус харьяалахын тийн ялгалын тэг хувилбараар илэрч байна. Харин “... дараа өртөөнд уулзъя” гэхэд орны утга илтгэнэ.

г. ... дараа болох биз дээ, энэ удаа чадахгүй юм байна гэж таныг бодож суух хооронд өөр хүн таны бүтээж болох байсан ирээдүйг өөрийн болгохоор нэг алхмын урд явна. Өөрийнхөө төлөө яг одоо алхам хий” (GAPE академи) гэхэд оруулсан баймж өгүүлбэрийн “дараа бол-” нь “хожим, хойно, сүүлд” гэх цагийн утга илэрхийлнэ.

Монгол хэлний daray-ā хэмээх үгийг бичгийн хэлэнд ихэвчлэн тохиолддог darui гэх үгээр солин найруулж болох мэт боловч утгын хувьд ялгаатай байна. Энэхүү darui гэх үгийг А.Попов, цаг заах дайвар үг (А.Попов 1847:177), Б.Х.Тодаева цагийн утгат дайвар үг (1951:159), Н.Поппе darui “нэн даруй” гэдгийн “i” нь салахгүй болсон (1987:264) гэсэн бол А.Лувсандэндэв нэр үгийн айгаас дайвар үгийн айд шилжиж буй үг (1956, 2002:73), харин Д.Цэрэнпил, Р.Кулман нар зөвхөн цаг заасан утгатай үг (2008:221) хэмээн үзжээ. Жишээлбэл, “Шагдар, эдний хаяанд буусан даруй элдвийг бодов. (С.Э., Сайн айл)” гэх өгүүлбэрийг “Шагдар, эдний хаяанд буусны дараа элдвийг бодов” гэж солин найруулж болохгүй байгаа нь darui/ daruyiqan хэмээх үг нь “даруй түргэн, нэн даруй, тэр даруй, удалгүй, сааталгүй, үтэр түргэн” буюу тухайн үйлтэй зэрэгцсэн цагийн утга илэрхийлж байна. Мөн darui гэх үг нь үйл үгийн өмнө тийн ялгалын ил ба далд нөхцөлөөр найрч холбогдоно. Жишээ нь: Хөндий талын зэрэглээ мяралзан жирлээх нь холоос үзэхэд сонин. Хэдэн жижигхэн юм түүний дунд сүүмэлзэх нь яахин даруй танигдана (Д.Н., Шувуун саарал); Харанхуй хад гэсэн нь яавч нэг газар байж тохирох тул, лав тийм газар уулзах гэсэн юм байна гэж сэтгэсэн

бөгөөд бас дахин нэг удаа шалгаж бодвол, ер үүнээс зайлахгүй болоод хуанлийг авч үзвэл наймдугаар сарын гучин бямба гариг нь яг энэ өдөр болсон тул, даруй яаравчлан босмогц (Д.Н., Харанхуй хад) гэх мэт.

Монгол хэлний корпуст $\text{dara}\gamma\text{-}\bar{a}\text{ ni } 6578$, эцэст нь 2009 удаа тохиолдож байгаа өндөр давтамжтай болохыг тоон үзүүлэлт илтгэнэ.

а. Тэнгэр, асар нарын дараа хүний орчлон, дараа нь адгуусны ертөнц, тэгээд бирдийн хорвоо мөн тамын амьтан ийм зургаан зүйл амьтад тус тусын орныг эзэгнэн суудаг гэж Санж гэгцэл бат итгэжээ (Л.Т., Оройгүй сүм) гэхэд “дараа нь” бол онцлон ялгасан утгатай бөгөөд “удаах нь, дараагийнх нь” гэх үгтэй адил утгатай байна.

б. Энэ учраас байгаагаа барьж хөдлөөд цааш нь юу болохыг дараа нь бодохоос өөр аргагүй ажээ. (Ч.Л., Тунгалаг Тамир) гэхэд сүүлд, хожим гэх утга илтгэнэ.

Нийт 377892 өгүүлбэртэй өгөгдөлд $\text{dara}\gamma\bar{a}\text{-qan/ } \text{dara}\gamma\bar{a}\text{-qan}$ нь 177 тохиолдож, 3754 -д эрэмбэлэгдэж, давтамж нь 9 дүгээр бүлэгт багтана.

а. Уг номд Б.Бат-Эрдэнэ аварга 1990 онд улсын баяр наадамд түрүүлэн даян аварга цол хүртээд ердөө сарын дараа-хан “Монголын нууц товчоо”-ны 750 жилийн ойн төрийн даншигт түрүүлэн Дархан аварга цол хүртэж байсан сонирхолтой үүх түүхийг бичжээ(dailynews.mn) гэхэд цагийн утгатай нэр үгийн ард тохиолдоно.

б. Наадмын дараахан говьд нохой гаслам халуун болдог билээ. (dailynews.mn); Бидний балчир байхад дайны дараахан хөдөө амарснаас хойш тийшээ зүглээгүй байх шүү. (С.Э., Дөрвийн бодол) гэхэд нэр үгийн ард тохиолдоно.

в. Би сумынхаа наадмын дараа-хан-аар ($N_{abl.}$) нутагтаа машинаар хүргүүлсэн юм. (С.Э., Зүүдний цагаан унага) гэх мэтээр ярианы хэлэнд тохиолддог.

г. Хүүтэй болж, дараа-хан нь ударник ажилчин цол хүртсэн (С.Э., Дөрвийн бодол) гэхэд “удалгүй” гэх цагийн утгаар өгүүлэгч, бичигчийн тухайн үйлд хандах баймж санааг давхар илтгэж байна. Мөн үүнийг “-сны дараа, дараахан нь” гэсэн задлаг хэлбэрээр солин найруулахад утга нь өөрчлөгдөхгүй юм.

Энэ үг нь “даруйхан” гэх үгээс ялгаатай утга илэрхийлнэ. Жишээ нь: Арга буюу эцсийн шийдвэрийг хүсэхэд, айлын залуу хар хүү докторт очих хүслийг гаргахад тэр ёсоор болж очиход, даруйхан нэг тасалгаанд оруулан, цэвэр цагаан бүтээлэгтэй орон дээр хэвтүүлэхэд, удтал биеэ угаалгасангүй хүн тул, тэр тасалгааны тунгалаг гэрэлтсэн цахилгаан гэрлийн туяанд цагаан бүтээлгээс тодхон ялгарч үзэгдэнэ. (Д.Н., Далдыг үзэгч); Робинсон ямар нэг адал явдалт зохиолд гардаг шиг юмтай учирлаа даа гэж бодовч ер нь жирийн амьдрал адал явдал хоёрыг зааглахад бэрхтэй цаг ч олон тохиолдож байсан тул ингэхэд бид чинь ямар хэлээр нэвтрэлцэх билээ гэ-ж даруйхан бодлоо (С.Э., Буцааж авах эрх) гэхэд “удалгүй ~ удахгүй~ мөдхөн” гэх хугацааны утга илтгэнэ.

Харин нэр үг бүтээж үзвэл, $\text{dara}\gamma\bar{a} + \text{la (V)} + \text{l (N}_{sub.}^{nomi.})$ нийт 377892 өгүүлбэртэй өгөгдөлд 58 тохиолдож, 9388 -д эрэмбэлэгдэж, давтамж нь 11 дүгээр бүлэгт багтана.

Энэхүү үүсмэл нэр нь тийн ялгалаар хэрхэн хувилж байгааг авч үзье. Жишээлбэл, он дараалал, эрэмбэ дараалал гэх мэт.

а. $\text{dara}\bar{y}\bar{a} + \text{la} (V) + \text{I} (N_{\text{sub.}}^{\text{nomi.}})$ Жишээ нь: Тоон дараалал-Ө арифметик прогрессын талаарх өмнөх хичээлүүдийн ойлголтоо хэрэглэн төрөл бүрийн асуудал шийдвэрлэх (medle.mn); Монголын түүхийн он тооллын дараалал-Ө ... (dailynews.mn); $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la} (V) -\text{I} -\text{un} (N_{\text{sub.}}^{\text{gen.}})$ Жишээ нь: Уншигч танаа толилуулан буй энэхүү дэвтэр бол ерийн нэг ном биш манай хүүхдийн уран зохиолын хагас зууны он дарааллын бичиг, хагас зууны тайлан юм. (Хүүхдийн уран зохиолын дээжис, Өмнөх үг, Л.Түдэв, Улаанбаатар, 197.) гэхэд харьяалахын тийн ялгалаар хувилж цагийн утгатай заана. $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\text{I}+\text{i} (N_{\text{sub.}}^{\text{accu.}})$, Жишээ нь: Нэгэнт 13 мянган хүн манай байгууллага дээр нэг дор ирэх бололцоогүй тул “Өдрийн сонин” дээр тэдний өдөр тийм дугаартай нь ирнэ үү гэсэн дарааллыг нийтлэх болно. (dailynews.mn) $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\text{I}+\text{tai} (N_{\text{sub.}}^{\text{comi.}})$, Жишээ нь: ... оролцогчдод эн тэнцүү дараалалтай шийдэхгүй бол болохгүй шүү (dailynews.mn); Цаашид амьтдыг эргээд байгальд нь буцаах арга хэмжээг шат дараалалтай-(г)-аар авна. (dailynews.mn); Юмыг дэс дараалал-тай зааж, нэг хэв маягт оруулж чаддаггүй юм. (Л.Т., Оройгүй сүм) гэхэд эгнээ, дэс дараа, дараалал эмх цэгцтэй гэх утгатай. Харин үүний эсрэг утгаар “ $\text{dara}-\bar{a}-\text{la}-\text{I} \bar{u}\text{gei}$ ” гэхэд үгүйсгэсэн “- $\bar{g}\bar{u}\bar{i}$ ” нөхцөлөөр хэлбэржиж “иргэдэд ... дараалалгүйгээр үйлчилж эхэллээ” гэвэл чөлөөтэй гэсэн утгатай бол харин “он дараалалгүй” гэвэл цагийн дараалал нь учир зүйн холбоогүй гэх санааг илтгэнэ.

б. $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\text{I}+\text{du} (N_{\text{sub.}}^{\text{dat.-loc.}})$ Жишээ нь: Тэр үед дараалалд зогсож байсан ихэнх иргэд бухимдаж маргааш л өглөө эрт ирэхээс гэсээр тарж одлоо. (dailynews.mn); $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\text{I}+\text{a}\bar{c}\bar{a} (N_{\text{sub.}}^{\text{abl.}})$ Жишээ нь: Самбарт бичигдсэн нэгээс мянга хүртэлх тоонуудын дараа-лалаас 2-т хуваагдах тоонуудыг арилгая. (<https://www.mmo.mn/olympiads/problems>); $\text{dara}\bar{a}-\text{la}-\text{I}+\text{i}\bar{y}\bar{a}\bar{r} (N_{\text{sub.}}^{\text{instr.}})$ Жишээ нь: Эхний хоёр өдрийн байдлаар медаль авсан орныг дарааллаар жагсаасан хүснэгтэд Монгол наймдугаарт жагсчээ (dailynews.mn). Үүнээс үзвэл, тус үүсмэл нэр нь нэрийн тийн ялгалаар хувилж өгүүлбэрт дараалал-Ө үүс- ($V_{\text{intrans.}}$), он дараа-ла-л-ын бичиг гэхэд харьяаны тодотгол, дараалал-Ө ав- ($V_{\text{trans.}}$), дараалал -Ө хүлээ- ($V_{\text{trans.}}$), дараалал-Ө нийтлэ- ($V_{\text{trans.}}$) гэхэд шууд тусагдахуун, дараалалд зогс- ($V_{\text{intrans.}}$), дарааллаас арилга- ($V_{\text{intrans.}}$), дарааллаар жагс- ($V_{\text{intrans.}}$), дараалалтай шийд- ($V_{\text{intrans.}}$) гэхэд хаана, хаанаас, хэрхэн гэсэн асуултад хариулагдаж шууд бус тусагдахуун гишүүний үүргээр ордог.

Мөн тус корпуст $\text{dara}\bar{y}-\bar{a}-\text{la}-\text{n}$ гэх үг 239 тохиолдож, 2866 -д эрэмбэлэгдэж, давтамж нь 9 дүгээр бүлэгт багтана. Ярианы хэлэнд $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\bar{y}\bar{u}-\text{lan} (V)$, $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\text{qu} (V)$, $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\bar{y}\bar{u}\text{l} (V)$, $\text{dara}\bar{y}\bar{a}-\text{la}-\bar{y}\bar{u}\text{l}-\text{qu} (V)$ хэмээн хэлбэржинэ.

а. Гэвч хоёр өдөр дараалан чуулганы танхимд сууж алжаасных уу, өнгөрсөн баасан гарагийн ээлжит чуулганд гишүүд төдийлөн идэвхтэй оролцсонгүй. (dailynews.mn) Мөн “он дараалан, жил дараалан, улирал дараалан”, сар дараалан, өдөр дараалан гэх мэт.

б. Гадаад дотоодын олон уралдаан тэмцээнд удаа дараалан амжилттай оролцсон. (dailynews.mn); Энэ үед Ар Монголын салангид халхын дөрвөн аймаг хоорондоо зөрчилтэй байснаас ээлж дараалан Манжид эзлэгдсэн байлаа (dailynews.mn); ... ойг угтсан арга хэмжээг шат дараалан зохион байгуулж буй юм байна (dailynews.mn)

в. Гэхдээ хэдийгээр бид өөрсдийгөө бусдаас илүү чадвартай гэж бодох дуртай ч, супер дасгалжсан хүн байх явдал зоос шидээд тав дараалан тоогоор нь буулгахтай адил боломжтой (dailynews.mn);

г. Харин их аварга хүнд хэцүү байдлаа зориг тэвчээр, сэтгэлийнхээ хүчээр туулж гаран зодог тайлах байтугай олон башё дараалан сайн барилдан, үзэгч олноо дахин баясгаж амжилтад хүрсэн түүхтэйг хэн хүнгүй мэдэх билээ гэхэд орсон “башё дараалан сайн барилд-” гэхийг “башё өнжилгүй сайн барилд-” гэж солин найруулж болно.

Дээрх өгөгдөлд $dara-\bar{a}-ki$ (N_{adj}) 291 тохиолдож, 2389-д эрэмбэлэгдэж, давтамж нь 9 дүгээр бүлэгт багтана.

а. Дараах хэдэн шөнө юм оёж үүр цайлгав (Д.Н., Цагаан сар ба хар нулимс); Энэ ярианы дараах орой Эрэнчин Батыг дагуулан гадаалахаар гандангийн захад гарлаа (Ч.Л., Тунгалаг Тамир); гэхэд цагийн утгатай нэр үгийн өмнө хамжин орж, үйлийн болсон цагийг заана. Үүнийг “удаах орой”, “удаах шөнө” гэх мэтээр солин найруулж болно.

б. Одоогоос арван жилийн тэртээх нэгэн цагаан сараар сэтгэлийн яруу туурвилч Б.Догмид ахын хамт энэ эрхэм найрагчийнд очсон минь санаанд тодхон байна. (dailynews.mn) гэхэд ... жилийн тэртээх ..., ... сарын тэртээх... гэхэд болж өнгөрсөн цагийг харин жилийн дараах ..., сарын дараах ... гэх мэтээр ирээдүйд болох цагийг заадаг.

в. Манай институт хэдхэн жилийн дараах улс орноо хөтлөн удирдах залуучуудын гол цөм нь байх болно(dailynews.mn).

г. ... баруун мөрөнд нь гараа хүргээд дараах хүн дээр очив (Л.Т., Оройгүй сүм) гэхэд удаах, дараагийн гэсэн үгээр солин найруулж болно.

1.б. хоршоо үгээр илрэх нь

Хэлний хэрэглээний явцад өгүүлэгч төгс санааг өгүүлбэрээр илэрхийлэхдээ монгол хэлэнд хоршоо үгийг ашиглах нь найруулгын ур маягтай холбоотой байдаг.

Дээр дурдсан монгол хэлний корпуст сонин нийтлэлийн найруулгын төрөлд $uda\bar{y}-\bar{a}$ $dara\bar{y}-a$ (1493), $uda\bar{y}-\bar{a}$ $dara\bar{y}\bar{a}lan$ (136), $uda\bar{y}-\bar{a}$ $dara\bar{y}-\bar{a}$ yin (116), $uda\bar{y}-\bar{a}$ $dara\bar{y}-\bar{a}$ $\bar{c}i-yin$ гэх зэрэг хоршоо үгийн тоон үзүүлэлтийн давтамж их байна. Жишээлбэл, Энэ үед удаа дараа хүрч ирсэн хүмүүс түүнийг гайхан магтах бөгөөд шувуун саарал гэж нэрийдэн, Сүрэнхүүгээс шалж, өдий төдий залуу тарган морины үнэ хаялцана (Д.Н., Шувуун саарал); ... удаа дараа хурал нээн давших замыг хүлээж (Б.Р., Үүрийн туяа); Австралийн тэр хэрэм зөвхөн үхэр хулганаар зогсохгүй зэрлэг динго нохой, молтогчин туулайн довтолгооноос хамгаалахад ч удаа дараа хэрэг болжээ (Л.Т., Үхэр хулгана); ... удаа дараа баатарлаг байлдаж. (montsame.mn) гэхэд тухайн үйлийг тогтмол хугацаанд дахин дахин, байнга тасралтгүй, хийх давтамж (frequency) -ийг зааж, харин “... хэрэгтэй гэж өөрөө удаа дараа ярьж байгаа” (dailynews.mn) гэхэд хоёр төгс өгүүлбэрийн хоёр дах үйл үгийн давтамжийг заасан нийлмэл өгүүлбэрт тохиолдоно.

Хамгийн чухал нь ээлж дараа гэж би бат итгэсэн хүн (С.Э., Баянбүрд) гэхэд шат дараа, эрэмбэ дараа, ээлж дараа гэсэн утгатай орно.

Харин хожим хойно гэх ойролцоо утгатай үгс хоршиж сүүлд, дараа гэх цагийн утга илтгэнэ. Жишээ нь: Гэвч хөрөнгө хогшил цуглуулан хожим хойно яах бол гэж амиа бодно гэдэг бол Лүмбэнгийн зан огт биш (С.Э., Эзэн)

1.в. давталтаар илрэх нь

$\text{dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ yin} > N_{\text{sub.}}$

-Ингэсэн цагт дараа дараа-(г)-ийн ажил ундарна даа гэж хэлье (dailynews.mn); Яагаад гэхээр шинээр сонгогдсон төр өөрийгөө ажиллуулах дараа дараа-(г)-ийн механизмыг гаргаж ирэх учиртай юм. (dailynews.mn)

$\text{dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ -}\dot{\text{ci}}\text{- yin} > N_{\text{sub.}}$

-Дараа дараачийн жилүүд хэчнээн өнтэй боловч Онгийн улаан нуур улам улам ширгэсээр нэг багахан тойром болов (С.Э., Баянбүрд); Гэхдээ дараа дараа-ч-ийн тоглолт болон аян замдаа дасаад ядрахаа байчихдаг юм (dailynews.mn) гэхэд харьяалахын тодотголын үүргээр орно.

$\text{dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ bar} > V$

Г.И.Рамстедт “*darān darāyār irtsyāw*” гэхийг “дараа дараагаар өөрийн цагтаа ирэх” гэсэн цагийн утга (1935:77) болон язгуур давтах онцлогийг ч давхар тайлбарлажээ. Жишээлбэл, -Цаадуул нь ч дараа дараа -(г)-аар бууж ирээд тавуул, зургуул, арвуул болж ирээд л наадмаа эхэлнэ (С.Э., Өвлийн ойд). Зам явах хүн морьтой, тэрэгтэй, явган, дугуйтай маш олон хэсэг, уурын тэрэгний хүмүүс хажуугаар дараа дараа-(г)-аар-аа зөрөлдөн өнгөрөх боловч Жүрмэд Дулмаа хоёрын морь явах шиг зохистой нь үгүй (Д.Н., Хаврын сайн өдөр)

$\text{dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ dara}\dot{y}\text{-}\bar{a} \text{ bar} + \text{iyan} > V$

- Би хэн байгаад хэн болов» гэж бодоход ч ядсан цагт маань тус дэм болж, алдаж осолдуузай гэж алтан сургаалаа хайрлаж байсан өвгөд хөгшид, алсын моринд дөрөөлж холын замд явахад хань түшиг болсон анд нөхөд минь дараа дараагаараа үзэгдэх шиг болж би тэдэндээ энэ намрын хонгор салхиар, олны маань урьдын нутаг дээрээс хайр талархлын үгээ илгээмээр байлаа (С.Э., Нутгийн салхи юу шивнэв) гэхэд язгуур давтаж утга лавшруулах утга илтгэхийн зэрэгцээ шууд бус тусагдахууны үүргээр орно.

Харин ярианы хэлэнд “-За, дараа дараа” гэхэд (хожим, сүүлд, одоо биш хожим, хойно) цагийн утга өгүүлэгчийн баймжаар илэрч байгаа бол нөгөө талаар “-За, дараа дараа” гэхэд (яршиг, төвөг) түүртсэн, төвөгшөөсөн мэдрэмж, сэтгэгдэл илэрхийлсэн өнгө аяс илэрч байна.

1.г. тогтвортой хэлц буюу чөлөөт бус холбоо үгээр илрэх нь

Орчин цагийн монгол хэлний $\text{dara}\dot{y}\text{-}\bar{a}$ гэх үг нь тогтвортой хэлцэд цөөн тохиолддог. Тухайлбал, “наадмын дараа намар” гэхэд энэхүү эс адилтгасан хэвшмэл хэлц нь хавар, зун, намар, өвөл хэмээх жилийн дөрвөн улирал ээлжилдэг эрс тэс уур амьсгалтай нүүдлийн мал аж ахуй эрхлэн байгальтайгаа зохицон амьдрах үйл явцад монголчууд цаг агаарын үзэгдлийг тааж мэдэх боломжгүй тул янз бүрийн байр сууринаас өөрсдийн үндэслэгээг дэвшүүлэхдээ “зун хэдий сайхан болсон ч цаг хатуурвал амаргүй” тул хадлан тэжээлээ бэлтгэж өвлийн бэлтгэл хийхийг сануулсан нүүдэлчдийн ахуй амьдралаас урган гарсан тодорхой утгатай.

Харин тодорхой юм, үйл явдал янз бүрийн шалтгааны улмаас тухайн өгүүлэгч бичигчийн байр сууринд өөр өөр утгаар ухаарагдаж байгаа нөхцөл байдлаас шалтгаалж үнэлэмж өөрчлөгдөж болно. Тухайлбал, “Найр наадам дагаад малчид завгүй “наадмын дараа намар” гэдэг хэлц үг үеэ өнгөрөөжээ (dailynews.mn)” гэхэд орчин үеийн хүмүүсийн амьдралын хэв маяг, хэрхэн өөрчлөгдөж буйг илэрхийлжээ.

Сүмд бүх лам нар толгой дараалан цугларчээ. (Л.Т., Оройгүй сүм); Мөргөлчид Бэрээвэн хийдийн нандин шүтээнүүдэд толгой дараалан мөргөж өдөржин явцгааж эцэж ядарчээ (Л.Т., Оройгүй сүм) гэхэд “толгой дараалан” гэдэг нь “нэг бүрчлэн, нэгд нэгэнгүй, хүн бүр, алгасахгүй, завсаргүй” гэхэд үгийн утга шилжиж хүнтэй хамаатай зүйлийг илтгэнэ. Үүнээс гадна амьгүй зүйлсийг “ширхэг дараалан” гэж хэлнэ. Тухайлбал, Өвгөн ухсан шороо чулууг ширхэг дараалан шахам томруулагч шилээр харан нэгжсэний үрээр баахан цахиур чулуу олж түүнээ палеолитийн үеийн соёлын зүйл гэж батлан өгүүлжээ (С.Э., Буцааж авах эрх).

“Айлын тусыг нүүснийх нь дараа, аавын тусыг үхсэнийх нь дараа (МАЗ); Гэм нь урдаа гэмшил нь хойноо; Гэнэн нь эхэндээ гэмшил нь эцэстээ; Гэнэн нь өмнөө гэмшил нь дараа” гэх хэвшмэл хэлц нь нийлмэл зэргэд өгүүлбэр бүтээхийн хамт эсрэгцсэн адилтгалын утга илэрхийлэх тохиолдолд дараа, хожим, сүүлд, эцэст зэрэг ойролцоо утгат үгс нь цагийн утга илэрхийлж байна.

Дээр өгүүлсэн орчин цагийн монгол хэлний “дараа” хэмээх үг нь дуудлага, бичлэг адил боловч утга, хэл зүйн шинжээрээ ялгаатай тул хоёрдох утга нь *daru-ā* II гэх үг нь цагийн утгагүй боловч дараах утгаар тохиолдоно. Жишээ нь: “Учир нь нүүн суухад дараа бол-но гэж боджээ (Ч.Л., Тунгалаг Тамир); Хүнд шархадсан боловч амьтай байсан хоёрыгоо тээр дараа бол-но гэж ... ирж байгаа нь энэ билээ (Ч.Л., Тунгалаг Тамир) гэхэд “дараа бол-” (төвөг бол-, тээр бол-, тээр дараа бол-) гэсэн утгаар “гэ”-т өгүүлбэрийн өмнө тохиолдож байна. “Хүнд шархадсан боловч амьтай байсан хоёрыгоо тээр дараа бол-но гэж ... ирж байгаа нь энэ билээ (Ч.Л., Тунгалаг Тамир)” гэхэд монгол хэлний “тээр дараа” гэх хоршоо үг нь “эсгий хийх газар нохой хэрэггүй”, “нэмэр биш нэрмээс болох”, “ажлын садаа” гэх хэлцийн утгатай төстэй буюу тухайн үйлд төвөг чирэгдэл, саад тотгор болж байгаа утгыг илэрхийлнэ. Харин “Гэдэс цатгалан, мөр бүтэн хойно хүүхдэдээ дараа бололгүй (бол-лгүй) явахаас дээр юмгүй гэдгийг хүмүүс ойлгох ч бий, үгүй ч бий (С.Э., Ээжийн авдар) гэхэд “төвөг, тээр дараа, саад болохгүй юмсан” гэх баймж утгыг задлаг хэлбэрээр илэрхийлж байна. Мөн “*daru-ā-tai*” гэх үг нь “өвгөн багшийгаа нас барсны дараа агуйнх нь мухарт чулуунд дараатай байсан судруудыг уншихын тулд сахил хүртэж, төвөд хэл үзэх болсон билээ (Г.А., Амь тавьж буй шувууны далавч) гэхэд шууд утгаараа үйлийн хамжсан тодотголын үүргээр орж харин “сэтгэлд дараатай” (төвөгтэй, ачаа болох, дараас болох) гэхэд утга шилжиж сөрөг мэдрэмж сэтгэгдлийг илэрхийлдэг бол “сэтгэлд уяатай, бодолд уяатай, мартаагүй л яваа...”, “Хүү чинь уул өргөж таныхаа ачийг хариулах, Урт холын бодлын тэнд дараатай л яваа шүү дээ” (Ш.Г., Ижий танаа) гэхэд эерэг үнэлэмж заана.

Монгол хэлний *daru-ā* хэмээх үгийг дээрх эрдэмтэд “цагийн утгат дайвар үг, цагийн дайвар үг, цагийн нэр”-д багтаан үзжээ. Иймд “*daru-ā*” хэмээх цагийн нэр нь идэвхгүй язгуурт “-γ-ā” дагавар залган бүтэж, нэрийн тийн ялгалаар заримдаг

хувилан үйл үгнээ холбогдохын зэрэгцээ, ихэвчлэн өгүүлбэрт ирээдүй цагт болох үйл явдлын цагийн дарааллыг заах хэмжүүр болохын зэрэгцээ “хожим, хойно, сүүлд” гэх үгтэй ойролцоо утгатай бол “урьд, өмнө, эхэнд” гэх үгтэй эсрэг утгатай.

Цагийн утгыг ойролцоо утгатай үгээр нь солин найруулах боломжтой. Жишээ нь: Хожим хайртай Нина хаана одсоныг мэдэхгүй, хэдийгээр эрэн сурвалжилсан боловч, эс олоод алмайран гайхсаар байв. (Д.Н., Харанхуй хад) гэхэд “хожим” гэх үгийг “сүүлд”; Байгалийн хишгийг “булаан” авахдаа хожим нь хүн өөрийнхөө амьдралд амь шиг хэрэгтэй юмсыг булааж үрэн таран хийчихсэн бүү байгаасай билээ. (С.Э., Баруун сарьдгийн вансэмбэрүү) гэхэд “хожим нь” гэх үгийг “дараа нь”; Тийнхүү ихэмсэглэх санаашрах алин боловч дулаан сайхан харагдаж, зүгээр л хэн хүний хүрээд ирж болох нутгийн нэг уул гэлээ миний хувьд бол урьд алдсаныг ч, хожим олохыг ч тэнцүүхэн ухаарах ухаарлыг өгөгч хүслийн цагаан оргил болон үзэгднэм (С.Э., Тал) гэхэд “хожим олох” гэдгийг “дараа ол-, сүүлд ол- ” гэх мэтээр солин найруулж болно. Мөн түүнчлэн “... урьд алдсаныг ч, хожим олохыг ч тэнцүүхэн ухаарах...” гэхийг “... урьд алдсаныг ч, хойно олохыг ч тэнцүүхэн ухаарах...” хэмээн солин найруулж бичихэд эсрэг утга илтгэж найруулгын өнгө аяс, учир зүйтэй илэрхийлэхийн зэрэгцээ өгүүлбэрт чөлөөтэй байрлахын хамт өгүүлбэрийн эхэнд ч тохиолддог.

Монгол хэлний өгүүлбэр дэх үгс нь үндсээр холбогдвол хамжих, нөхцөлөөр холбогдвол найрах арга гэж үздэг. Тэмдгийн ба тооны нэр нь нэр, үйл үгнээ, авиа ба дүрс дуурайх үг нь зөвхөн үйл үгнээ тодотгох утгатай тэг үндсээр хамждаг. Орон цагийн нэр нь бусад үгсийн аймгийн байранд орж, бусад үгсийн аймгийн үүргийг гүйцэтгэх ч тохиолдол цөөнгүй байна. Эдгээрийг өгүүлбэрийн гишүүний хувиргал гэнэ. Өгүүлбэрт *дараа-а* гэх үг нь арын нэр ба үйл үгэндээ хамжих аргаар үндсээрээ холбогдоно.

а. нэр үгийн өмнө хамжсан тодотголын үүргээр; (*дараа-а* > N) Тухайлбал,

а.1. Гэхдээ л олон хүн түүнийг дараа жил аварга болно гэдэгт итгэж байсан юм. (*dailynews.mn*); Тэгээд Үндэсний аудитын газрын дүгнэлтийн дагуу төлөвлөсөн хэмжээгээр нь оруулаад үлдсэнийг нь дараа он-д нь оруулж байгаа. (*dailynews.mn*); Ингэснээр Засгийн газраас дараа сар-ууд-д газрын тосны бүтээгдэхүүний хилийн үнэ огцом өссөн тохиолдолд татварын хувь, хэмжээг бууруулж дотоодын зах зээл дэх жижиглэн худалдааны үнийн огцом өсөлтийг сааруулах татварын нөөц бий болгож байна. (*dailynews.mn*); “За, дараа долоо хоногт уулзацгаая” гэхэд өгүүлэгчийн хийх үйл явдлын ирээдүйд болох цаг хугацаа нь тодорхой болно. Мөн дараа жил, дараа улирал, дараа сар, дараа долоо хоног, дараа өдөр зэрэг хэлбэр олонтоо тохиолддог.

а.2. Мөн дараа үе, дараа үед (эхэн үе, эхэн үед, удаах үе, удаах үед, сүүл үе, сүүл үед); дараа хугацаанд гэх мэтээр цагийн утга илэрхийлж болно. Жишээ нь: Эндээс Монголд улс төрийн шинэчлэлийн нэг дараа үе (шинэ үе) эхэлж байна гэж дүгнэх бүрэн боломжтой. (*dailynews.mn*) гэх мэт.

Үүнээс гадна орчин цагийн монгол хэлний жишээнд “дараа төлбөрт миний моба багц” (<https://support.mobicom.mn>) гэхэд “хожим, сүүлд төлөх” гэх утгаар,

харин “Дараа өртөө” гэх дууны нэр нь орны утгаар орсон болохыг тухайн дууны шүлгийн дахилтын хэсэгт “дараа өртөөнд уулзъя” хэмээн хаана уулзах газрыг товлон өгүүлэхэд ашигласан нь бичгийн хэлний бус, ярианы хэлний жишээ болох нь тодорхой юм.

б.Үйл үгийн өмнө хамжсан тодотголын үүргээр ($\text{dara}\gamma\text{-}\bar{a} > V$) тохиолдоно. Тухайлбал,

б.1. Эрдэнэ ч босож гарах гэхэд нь “дараа уулзаж тавтай ярь” гэж хэлэв. (Ч.Л., Тунгалаг Тамир); “За, дараа уулзацгаая.” гэхэд өгүүлэгч хэсэг хугацааны дараа уулзах хүсэлтэй боловч хугацаа нь тодорхой бус “хожим, сүүлд” гэх үгтэй ойролцоо утгатай үйлийн хамжсан тодотгол болно.

б.2. Монгол хэлний ярианд “Чи дараа бол л доо; Дараа болох биз дээ” гэхэд “дараа боло-, дараа ашигла-, дараа уулз, дараа ир-” гэхэд “сүүлд, хожим, хойно” болох цагийн утга заана.

б.3.Тэгээд эхний удаа “дараа өлсөхөөрөө иднэ” хэмээн бодоод агуйнхаа буланд үлдээсэн байж таарна (dailynews.mn).

Өгүүлбэрийн гишүүд нь үйл өгүүлэхүүн гишүүнд үндсээр холбогдвол хамжих, харин нөхцөлөөр холбогдвол найрах аргаар холбогдоно.

Харилцааны нэгж болох өгүүлбэрт монгол хэлний $\text{dara}\gamma\text{-}\bar{a}$ гэх орон цагийн нэр нь харьяалахын тийн ялгалаар нэр үгтэй, гарахын тийн ялгалаар хааяа өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар үйл үгэнд найран захирагдана.

Орчин цагийн монгол хэлэнд $N_{\text{sub.}}^{\text{gen.}} + \text{dara}\gamma\text{-}\bar{a}$ буюу харьяалахын тийн ялгалаар хувилсан нэр үгийн ард найрч туслах үгийн үүргээр орохдоо ялгасан тохиолдолд ил хэлбэрээр илэрч байгаа жишээг тоон үзүүлэлтээс ажиглахад дээрх корпуст давтамжаараа янз бүр байгаа шалтгааныг хэрэглээний жишээнээс тодруулж болно.

1.а. жилийн~ (3602), хоногийн~ (2084), минутын~ (877), хугацааны~ (697), сарын~ (594), хоногийн ~ (240), цагийн ~ (587) гэхэд тоон үзүүлэлт давтамж өндөр байгааг харуулж байна. Жишээлбэл, Жилийн дараа инженер нэртэйгээс биш нэг ёсондоо ой хамгаалагч болоод л ирнэ дээ. (С.Э., Өвлийн ойд); Хэдэн жилийн дараа сайхан төгөл болж мэдэхээр тун дажгүй ургаж байна. (dailynews.mn); Гурван сарын дараа тэд хоцрогдлоо нөхөж, ангидаа буцсан. (dailynews.mn); ... эхлэх цагаасаа нэг цагийн дараа эхэллээ (dailynews.mn) гэхийг одоо цагаас дүгнэвэл өнгөрсөн цагт болсон, эсвэл ирээдүйд болох үйл явдлын цагийг илэрхийлнэ.

б. хормын ~ (33), мөчийн ~ (31), өдрийн ~ (31) гэхэд цөөн давтамжтай илэрч цаг хугацаа заасан нэр үгийн ард туслах үгийн үүргээр тохиолддог. Жишээ нь: ... хорин минутын дараа очъё. (dailynews.mn); Хэдхэн хормын дараа Монголчууд та бидний хамтын бүтээл болсон эдүгээгийн 2009 он түүх болж үлдэнэ (dailynews.mn). Тэгэхээр яг ямар хугацааны дараа англиар чөлөөтэй ярьдаг болох вэ? (dailynews.mn) гэхэд захирагдаж байгаа үйл үгийн цагтай зохицож байна.

в. орчмын ~ (31), зууны ~ (14) гэхэд хэсэг хугацааны дараа болох үйлийн цагийг илэрхийлнэ.

2. $N_{\text{sub.}}^{\text{gen.}} + \text{daray-}\bar{a}$

сонгуулийн~ (398), явдлын~ (236), хурлын~ (200), тоглолтын~ (187), уулзалтын~ (112), наадмын ~ (94), тэмцээний~ (92), ёслолын~ (89), наадмын~ (56), хуралдааны~ (40), борооны~ (40), мэдээллийн~ (36), барилдааны~ (30), хуралдааны~ (30), жагсаалын~ (30), хэлэлцээний~ (27), дүнгийн~ (24), ажиллагааны~ (23), тэмцээний~ (22), үерийн~ (21), хоолны~ (20), нээлтийн~ (20), баярын~ (20), нийтлэлийн~ (20), давааны~ (18), эргэлтийн~ (17), айлчлалын~ (12), Олимпын~ (11) гэх мэт. Жишээ нь: Тоглолтын дараа өөрсдөө яг хүүхдүүд шиг хөөрчихсөн байдаг аж. Сонгуулийн дараа чимээгүй болдог (dailynews.mn) гэхэд хэзээ, хэдүйд хэмээн үйл явдлын эхлэх цагийг заана.

3. $N_{\text{sub.}}^{\text{gen.}} + \text{daray-}\bar{a} -\text{qan-iyar}$ ($N_{\text{sub.}}^{\text{abl.}}$), $N_{\text{sub.}}^{\text{gene.}} + \text{yarui} -\text{qan-iyar}$ ($N_{\text{sub.}}^{\text{abl.}}$)

Жишээ нь: Би сумынхаа наадмын дараахан-аар нутагтаа машинаар хүргүүлсэн юм (С.Э., Зүүдний цагаан унага) гэж ярианы хэлэнд өгүүлэгчийн баймж санааг илэрхийлнэ.

4. $N_{\text{pron.}}^{\text{gen.}} + \text{daray-}\bar{a}$

үүний ~ (2,385), түүний ~ (206), үүнийхээ~ (54), түүний~ (51), тэрний~ (36), тэдний ~ (3.9) үүнийхээ~ (38), бүхний ~ (74) Жишээ нь: Миний үс ч яамай ардын засаг мандаж, аймгийн хулгайч хүртэл дөнгөнөөсөө салж байхад бид үүний дараа үснээсээ салах нь зөв юм биш үү. (Ч.Л., Тунгалаг Тамир); Түүний дараа хэн нь юун дээр алдсан, хожсоныг ярих хэрэгтэй гэж Бат бодно (Ч.Л., Тунгалаг Тамир).

Дээр дурдсан монгол хэлний өгөгдөлд $\text{daray-}\bar{a}$ хэмээх үг харьяалахын тийн ялгалаар хэлбэржиж нэр үгтэй холбогдож найран захирагдсан тохиолдол 743 удаа байхын хамт өгүүлбэрт харьяаны тодотголын үүргээр орно. ($\text{daray-}\bar{a}$ -yín ($N_{\text{gen.}}$) + $N_{\text{sub.}}$)

а. 1. Дараагийн байшин-д том авдруудаар дүүрэн гурил, цагаан шар будаа, хайрцаг хайрцагаар чавга, нар хамба... байлаа. (Ч.Л., Тунгалаг Тамир); Хурд хэтрүүлбэл, дараагийн пост таныг саатуулж картанд чинь төлбөр тавигдана. (dailynews.mn) “дараагийн зогсоол, дараагийн сум, дараагийн газар, дараагийн талбай, дараагийн цонх, дараагийн хаалга” гэхэд орон байр заана.

а. 2. Хоноод өглөө дараагийн өртөө- Ө хүрч чадах байх гэж Бат хэлэв. (Ч.Л., Тунгалаг Тамир); Хонгор банди нарын хамт нэг хашааны үүдэн дээр зогсон, гуйж баймааж олсон боовны хэлтэрхий, үмх өөхөө хар хүүдийдээ хийгээд дараагийн хашаа руу явж байсан Жаргал дээр очив (Ч.Л., Тунгалаг Тамир) гэхэд зүг чиглэл заана.

б. Цааш асуудал хэрхэн өрнөснийг дараагийн долоо хоногт ярьж өгье. (dailynews.mn); ... би дараагийн өдрүүдэд морь унаад нутгаараа зугаацан явахдаа адуу л тааралдвал өнөөх зүүдний цагаан унага минь яваа юм биш биз гэж хардаг байлаа (С.Э., Аян замын бодол буюу уянгын эрих) гэхэд цаг хугацаа заана. Үүнээс үзвэл, “ $\text{daray}\bar{a}$ ” гэх үг нь харьяалахын тодотголын үүргээр орон байр, цаг хугацаа заасан нэр үгийн өмнө тохиолдохын зэрэгцээ үйл өгүүлэхүүнд захирагдаж орон цагийн байц гишүүн болно.

в. Жагсаалтын дараагийн байр-т Японы Токио, Йокохама, Нагоя хот орсон байна (dailynews.mn) гэхэд эрэмбэ дарааг заана. Зэрлэг сонгинын үнэр бол миний

чамд идүүлэх дараагийн хоол мөн (Л.Т., Оройгүй сүм); Ингээд дараагийн хүн-ий өмнө очиж асуултаа дахин тавилаа (Л.Т., Оройгүй сүм); Ордоос олсон орлогоос эхний ээлжинд дэд бүтцэд, дараагийн ээлж-н-д иргэдэд хувь хүртээж болно. (dailynews.mn) гэхэд ээлж дарааг заана. Уншигчид дараа-г-ийн цуврал-аас маш сонин үйл явдал, танин мэдэхүй, адал явдал, гүн ухаан, их ухаарлыг тэсэн ядан хүлээж байгаа нь лавтай. (dailynews.mn) гэж үргэлжлэх дарааллыг заана.

д. Эрдэнэ дараа-г-ийн-х-аа үг-ийг бэлтгэж байлаа. (Ч.Л., Тунгалаг Тамир)

Мөн $\text{dara}\bar{y}\bar{a}\text{-}\dot{\text{c}}\text{i-yin}$ ($N_{\text{gen.}}$) $> N_{\text{sub.}}$ гэх бүтэц нь дээрх корпуст 36 тохиолдож 13.5 -д эрэмбэлэгдэж, давтамж нь 12 дугаар бүлэгт байгаа нь харьцангуй цөөн давтамжтай байна.

а. ... дараа-ч-ийн буудал-Ø ойртож цахилгаан тэрэг удаашрангуут үсрэн бууж... (С.Э., Оготны нүхэн дэх сувд); Дуу уянгалсаар, дараа-ч-ийн хөтөл дээгүүр давж байна. (dailynews.mn) Надад муу янгиа тохоод дараа-ч-ийн өртөө-Ø хүргэж чадах хөл хөнгөнтэй үзэмж муутай гүү, азарга аль. Тэр хулгайчид хэрэг болох юм надад байхгүй гэж Бат шийдэмгий хэлэв. (Ч.Л., Тунгалаг Тамир) гэхэд орон байр, зүг чиглэл заана.

б. Тэгээд дараа-ч-ийн намар оройхон болж байхад явган явсаар Хатгалд хүрээд ирлээ. (С.Э., Баруун сарьдгийн вансэмбэрүү) гэхэд цагийн утгаар орно.

в. Тэгтэл гэнэт газар дэлхий хотосхийн доргиж, хөлби үсрэн дараачийн эгшин-ээ аянга ниргэх адил их чимээ нүргэлэн маш өндөрт хэдэн арван галт бөмбөг дэлгэрч харагдав. (С.Э., Ёслолын буудлага); Дараа-ч-ийн эгшинд улаан сүйх тэрэг ухаа тоосон дунд хэд үсрэн гялалзсанаа газар цөмрөн орох мэт гэнэт алга болжээ (С.Э., Халуун өдөр) гэхэд үйл явдлын цагийн дарааллыг заана.

г. Аваргуудын лигийн дараа-ч-ийн шат-н-д шалгарав. (dailynews.mn); Тэмцээн явуулах журмын дагуу эхлээд сонгон шалгаруулах зургаан гүйлтийг зохиодог бөгөөд тав, таван тамирчин оролцсон энэ гүйлтээс гурав нь дараачийн шатанд шалгардаг юм байна. (dailynews.mn) гэхэд дэс дарааг илтгэнэ.

д. Ирэх зургаадугаар сард дараа-ч-ийн ээлж явах юм байна. (dailynews.mn); Миний дараа-ч-ийн дүүг Нарангуа гэдэг. (dailynews.mn) гэхэд ээлж дарааг илтгэнэ.

е. Анхны дарга Дармаа, дараа-(ч)-ийн-х нь нөгөө соёо Жамц. (С.Э., Дөрвийн бодол)

Орон цагийн харьцааны нэрс нь нэрлэх, харьяалахаас гадна гарах, үйлдэхийн тийн ялгалын нөхцөлт өөр нэрийг захирч чадна (1968:25) гэж Ш.Лувсанвандан үзжээ.

Монгол хэлний $\text{dara}\bar{y}\bar{a}$ гэх үг нь ихэвчлэн гарахын тийн ялгалаар хэлбэржиж заримдаа өгөх орших, үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржвэл үйл үгэнд найран захирагдана. Жишээлбэл,

Орчин цагийн монгол хэлэнд “дараа-(н)-аас, дараа-(г)-аас” гэж хэлэхэд “н~г” хоёр нь сэлгэх тохиолдол байна. Дээрх монгол хэлний корпуст энэ хэлбэр нийт 35 тохиолдож, 13852-д эрэмбэлэгдэж, давтамж нь 12 дугаар бүлэгт багтаж байгаа тул цөөн ашигладаг байна. Жишээлбэл, а. Саяхан утсаар ярихад дунд сунгааны дараанаас наашаа орж ирнэ гэсэн. (dailynews.mn); 193 см өндөр, 86 кг жинтэй

тэрбээр 17 настайгаасаа Словенийн сагсан бөмбөгийн дээд лигт тоглож эхэлснээс 3 жилийн дараанаас л үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүндээ багтаж, дэлхийн аварга, европын аваргад оролцож, улсынхаа аваргын алдрыг хүртэж байсан. (dailynews.mn); Долдугаар сард болдог үндэсний баяр наадмын дараа-(г)-аас эхлэн хүмүүс найз нөхөд гэр бүлээрээ баг болон Монгол орны хөдөө нутгаар зугаалан, орон нутагт амьдардаг төрөл төрөгсдөдөө айлчилдаг (dailynews.mn) гэхэд үйлийн эхлэх цагийг заасан цагийн байц гишүүн болно. б. ...3 жилийн дараанаас л үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүндээ багтаж ... (dailynews.mn); Үлдэх хоёр нь 2 жилийн дараагаас дагаж мөрдөх юм (dailynews.mn) гэхэд үйлийн эхлэх цагийг заасан цагийн байц гишүүн болно.

Харин Л.Мишиг “элдэв утгатай нэрийн ай бол дагавар үг дагуулж цагийн байц болдог (1957:117) гэжээ. Монгол хэлний дээрх корпуст $\text{dara}\gamma\text{-}\bar{\text{a}}\text{-}\bar{\text{c}}\text{i}\text{-}\text{a}\text{s}\text{a}$ ($N_{\text{sub.}}^{\text{abl.}}$) $>V$ гэх хэлбэр 3 удаа л тохиолдож байгаа нь бичгийн хэлэнд бараг ашигладаггүй харин ярианы хэлэнд цөөн байна. Жишээ нь: Б.Цэдэн-Иш гуай жанжин Сүхбаатар өөд болсноос хойш гурав дөрөвхөн жилийн дараа-(ч)-аас эхлэн Монголын хил дээр очсон байдаг (dailynews.mn) гэх мэтээр ихэвчлэн “эхлэх, үүсгэх, бий болгох” гэсэн утгатай үйл өгүүлэхүүнд захирагдаж өгүүлбэрт гарахын тийн ялгалаар $\text{dara}\gamma\text{-}\bar{\text{a}}\text{-}\text{a}\text{s}\text{a}$ ($N_{\text{abl.}}$) $> V$ хэлбэржиж цагийн байц гишүүний үүргээр тохиолдоно.

дараад нь ($\text{dara}\gamma\text{-}\bar{\text{a}}\text{-}\text{d}\text{u}$ $n\bar{\text{i}}$ ($N_{\text{dat-loc.}}$) $>V$) хожим, сүүлд нь гэсэн цагийн утга илтгэж, үйл өгүүлэхүүнд захирагдан өгөх оршихын тийн ялгалаар хэлбэржиж цагийн байц гишүүн болно.

а. Хар эрчээрээ унаж явсан тэр цэгүүд хэдхэн хормын дараад ($\text{dara}\gamma\text{-}\bar{\text{a}}\text{-}\text{d}\text{u}$ ($N_{\text{dat-loc.}}$) $>V$)... дэлгэрэв. (С.Э., Улаан шүхэр);

б.... аймгийг бүрэлдүүлж дараа-д нь зүүн тийш буцаж нүүн ... (mn.wikipedia.org)” гэхэд дараалал заасан утга илтгэнэ.

Үйлдэхийн тийн ялгалаар илрэх нь: $\text{dara}\gamma\text{-}\bar{\text{a}}\text{-}\text{b}\text{ar}$ ($N_{\text{sub.}}^{\text{instr.}}$) $>V$

а. Чехийн бизнес эрхлэгчид хэдэн жилийн дараагаар өсөн дэвшиж буй Монгол Улс руу ирсээр ... (mzv.gov.cz); Ус, цаг уур, орчны шинжилгээний газраас нийслэлийн нутаг дэвсгэрийг бүхэлд нь хамарсан хүчтэй аадар бороо нэг цаг орчмын дараагаар дахин орно гэж мэдээллээ (dailynews.mn)

гэхэд үйлдэхийн тийн ялгалаар хэлбэржиж үйл явдлын цагийн дарааллыг учир зүйтэй илтгэж үйл өгүүлэхүүнд захирагдаж цагийн байц гишүүний үүргээр орно.

б. Цаадуул нь ч дараа дараа-(г)-аар-аа бууж ирээд тавуул, зургуул, арвуул болж ирээд л наадмаа эхэлнэ (С.Э., Өвлийн ойд) гэхэд тасралтгүй цуваа, ээлж дарааг илтгэнэ. -“Удалгүй дүгрэг том нар мандан гарч ирэхэд урьдаар баруун ба хойт уулсын орой ба энгэрээр гэрэл тусаад, дараагаар өмнөх их талд туяа нийтлэн шарлав” (Д.Н., Адууны манаанд) гэхэд үйл явдлын дэс дарааг илтгэнэ.

Ш.Лувсанвандан монгол хэлний бүтэц үгэлбэр нь хэлэх аялгаас гадна, үг нөхцөл хоёрын аль нэггүйгээр утга төгс бүтэц өгүүлбэр болж чадахгүй (1968:14) гэжээ. Иймд, үүнээс үүдэн орчин цагийн монгол хэлний $\text{dara}\gamma\text{-}\bar{\text{a}}$ гэх цагийн нэр өгүүлбэрт цагийн байц гишүүн болон цагийн байц гишүүн өгүүлбэрт ямар үүргээр тохиолдож болохыг дараах жишээгээр тайлбарлаж болно.

Ш.Лувсанвандан нийлмэл үгүүлбэр бол үгүүлбэр зүйн дээд зэргийн нэгдэл юм (1951:115) гэжээ. Иймд түүнийг бүрдүүлэгч гишүүн өгүүлбэр ч чухал ойлголт болно. Ш.Барайшир цагийн байц гишүүн өгүүлбэр нь гол өгүүлбэртээ цаг заасан байцын үүрэг гүйцэтгэж хэзээ, хэдийд, хэдийгээр, хэдийнээс гэх зэрэг асуултанд хариулагддаг (1964:77).

Үүнээс үзвэл, орчин цагийн монгол хэлэнд тодотгон холбох нөхцөл нь тодотгох утгатай тэг үндсээр жинхэнэ нэрнээ хамжин орж, хамжсан тодотгол гишүүн өгүүлбэр бүтээдэг. Гэвч заримдаа арын жинхэнэ нэрээ хурааж нэрийн тийн ялгалын нөхцөл болон туслах үг бүхий задлаг хэлбэрээр нийлмэл өгүүлбэр бүтээдэг.

Ш.Лувсанвандан энгийн нийлмэл үгүүлбэрийн бүрэлдэхүүнд багтсан үгүүлбэрүүдийг эцсийн ба эцсийн бус гэж хоёр хэсэгт хувааж, хавсарсан нийлмэл өгүүлбэрийн бүрэлдэхүүнд багтсан үгүүлбэрүүдийг гол ба гишүүн өгүүлбэр гэж ангилж болно (1951:267).

Иймд монгол хэлний хавсарсан нийлмэл өгүүлбэрийн бүрэлдэхүүн дэх цагийн байц гишүүн өгүүлбэрийн цагт нэрээр хэлбэржсэн өгүүлэхүүнийг харьяалахын тийн ялгалаар хувилгахад туслах үүргээр орсон *дагау-а* гэх үг бүхий задлаг аргаар цагийн утга илэрхийлдэг. Тухайлбал,

V + -сан + -ы_(Nsub. gen.) + дараа

дууссаны~ (1312), гарсны ~ (1107), хийсний~ (746), болсны~ (671), авсны ~ (426), сонссоны ~(269), ирсний ~(247), өнгөрсний ~(231), зарласны ~(227), орсны ~(211), барсны ~(195), тарсны ~(189), явсны ~(187), уулзсаны ~(161), авсныхаа ~(154), танилцуулсны ~(153), өгсний ~(143), баталсны (137), батлагдсаны ~ (126), өгснийхөө ~ (124), уулзсаныхаа ~ (119), төгссөний ~ (115), болсны ~ (115), танилцсаны ~ (112), ирснийхээ ~ (112), огцорсны ~ (112), хэлэлцсэний ~ (107), ажилласны~ (107), гаргасны~ (106) гэх мэт. Үүнийг үйл үгийн тусах, эс тусах шинжээр нь бүлэглэж үзэхэд эс тусах үйл үг нь олон тохиолдож байна. Тухайлбал,

а. (Vtrans.) хийсний~, авсны ~, сонссоны ~, зарласны ~, авсныхаа ~, танилцуулсны ~, өгсний ~, баталсны~, өгснийхөө ~; ингэ-сэн-ий дараа (88), тэг-сэн-ий дараа гэх мэт.

б. (Vintrans.) дууссаны~, гарсны~, болсны~, ирсний~, өнгөрсний~, орсны~, барсны~, тарсны~, явсны ~, уулзсаны~, батлагдсаны~, төгссөний~, болсны~, танилцсаны~, огцорсны ~, хэлэлцсэний ~, ажилласны ~, гаргасны~, уулз-сан-ы-(х)-аа~, ир-сэн-ий-(х)-ээ~ гэх мэт.

Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй номд цагийн байц гишүүн өгүүлбэрийн өгүүлэхүүн нь дан нөхцөл үйлээр илэрвэл гол өгүүлбэртэйгээ шууд хэлбэрээрээ, харин үйлт нэр, нэр үгээр илэрвэл 1. тийн ялгалын нөхцөлөөр, 2. зарим дагавар үгээр дамжин холбогддог. Гишүүн өгүүлбэрт нь “үед, зуур, хоорондуур, хойно, хойш, өмнө, даруйд, дээр, хойгуур, хамт, зэрэг, дараа” гэх мэт үгс холбоосын үүргээр хэрэглэгдэнэ (1989:238) гэжээ.

Энэхүү задлаг бүтэцтэй өгүүлбэр ярианы хэлнээс илүү бичгийн хэлэнд тохиолдож байгаа тул жишээг түүвэрлэн аваад задлан шинжилж, нэгтгэн

дүгнэхэд найруулга зүйн түвшинд уншигч бичигч санаагаа илэрхийлэхэд чухал ач холбогдолтой байна. Жишээлбэл,

$$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа}]} > S$$

Жишээ нь: Нутаг ус нэр алдраа асуулцсаны дараа Төмөрт хоол, айраг өгөв. (Ч.Л., Тунгалаг тамир); Гэрийнхнээ явсны дараа хоёр хүү нэг хэсэг дуу шуу ч үгүй, гэрийн зүүн талд зэрэгцэн суужээ (Ч.Л., Тунгалаг тамир). Хүү: “тэгвэл эртхэн явж барин уясугай” гээд цайгаа ууж базаасны дараа, эцэг хүү хоёулаа адуучин ба багачуудаас хэд хэдийг дагуулан зэрэгцэн хатируулсаар, адуун дээрээ хүрч очив. (Д.Н., Адууны манаанд). Тийнхүү цаг хэртэй болсны дараа салхи мөн гэнэт намдсан ч гэлээ тэнгисийн мандал нэг хэсэгтээ тайвширсангүй. (С.Э., Изабелла); Лодой баян, бэйсийг үг хэлсний дараа өвгөн Луузан босож ... (Б.Р) гэхэд задлаг бүтэцтэй цагийн байц гишүүн өгүүлбэр бүтээхэд өнгөрсөн цагийн тодотгон холбох нөхцөлөөр хэлбэржсэн үйл үг нь харьяалахын тийн ялгал болон цагийн нэрээр хэлбэржсэн байна. Хэрвээ эс ялгах утга илтгэж байгаа тохиолдолд “Би баруун хойно нь нэг гөрөөсний ширэн дэвсгэр дээр хагас завиран суусны дараа амар мэндийг мэдэлцэв. (Д.Н., Харанхуй хад)” гэхэд цагийн байц гишүүн өгүүлбэрийг

$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа}]} > S$ гэхийг $S_{[V + \text{-сан} + \text{-ы} + \text{хойно}]} > S$ хэмээн солин найруулж болно.

$$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа-г-аас.} (\text{Nsub.}^{\text{abl.}})]} > S$$

Жишээ нь: Шигүши цолыг анх Юань улсын үеэс хэрэглэж эхэлсэн. Тогоонтөмөр хаан, Дайду хотоос гарсны дараа-(г)-аас отог, аймгийн зарим ноёдын хэрэглэж байсан цол юм. (dailynews.mn)

$$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа-н-аас.} (\text{Nsub.}^{\text{abl.}})]} > S$$

Жишээ нь: Британид болсон санал асуулгаар тус улс Европын холбооноос гарахаар шийдвэрлэсний дараа-н-аас арьс өнгө, гарал үүслээр нь ялгаварлах сэдэлтэй. (dailynews.mn)

$$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа-ч-аас.} (\text{Nsub.}^{\text{abl.}})]} > S$$

Жишээ нь: Гал гарсны дараа-(ч)-аас эхлээд л тэндээс хамгаалалтад гарч ажиллаж эхэлсэн. (dailynews.mn);

$$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа-г-аар.} (\text{Nsub.}^{\text{instr.}})]} > S$$

Жишээ нь: Ийм юм болсны дараа-г-аар амьд явах ч сонирхолгүй шиг санагджээ. (Л.Т., Оройгүй сүм); “Урлах-Эрдэм” сургуулиа төгссөний дараагаар нэг хэсэг хувцас загварын салон ажиллуулж байсан. (dailynews.mn)

$S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа-н-аар.} (\text{Nsub.}^{\text{instr.}})]} > S$, $S_{[V + \text{-сан} + \text{-ы} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + \text{дараа-ч-аар.} (\text{Nsub.}^{\text{instr.}})]} > S$ зэрэг бүтэц нь ярианы хэлэнд ихэвчлэн ашигладаг боловч заримдаа сонин нийтлэлийн бичвэрт “...Хурлын танхимд зохион байгуулагдсан албан ёсны уулзалт өндөрлөсний дараачаар...” гэх мэтээр тохиолддог.

$$S_{[V + \text{-сэн} + \text{-ий} (\text{Nsub.}^{\text{gen.}}) + (\text{x})\text{-ээ дараа}]} > S$$

-Хурлын хоёр дахь өдөр тэр үг хэлсэн. “Ра-2” папируус завиар Атлантын гадаад далайг туулж Америкийн эрэг хүрсний-х-ээ дараа Нэгдсэн Үндэстний Байгууллагад бичсэн илтгэлээсээ иш татаж ярьсан нь эрдэмтдийн сэтгэлийг их догдлуулав. (С.Э., Баянбүрд)

$$S_{[V + \text{-сэн} + \text{-ий} (N_{\text{sub.}}^{\text{gen.}}) + (x) \text{-ээ дараа-хан}]} > S$$

-Төмөрт түлхүүлснийхээ дараа-хан найз захирагчийндаа айлчлан очиж цадиггүй зарцаас хариугаа авах тухай зөвлөн ярилцжээ. (Ч.Л., Тунгалаг тамир)

$$S_{[V + \text{-сэн} + \text{-ий} (N_{\text{sub.}}^{\text{gen.}}) \text{ дараа-д}]} > S$$

- ... энд ямар учраас ингэж уйтгарлан сууна” гэж лавлаж мэндийг мэдэлцсэний дараад ... тантай учирсандаа түмэнт баярлана. (Д.Н., Агуу хүчтэн)

Дээрхээс үзвэл, орчин цагийн монгол хэлний *дараа-а* хэмээх үг өгүүлбэрт дан ба холбоо үгээр хэрхэн илэрч байгаа, мөн энгийн ба нийлмэл өгүүлбэрт бусад үгстэй хэл зүйн ямар харьцаатай хийгээд задлаг аргаар цагийн байц гишүүн өгүүлбэр гол өгүүлбэртэйгээ холбогдож байна.

Орчин цагийн монгол хэлний дараа/даруй хэмээх үг нь нийлмэл өгүүлбэрт холбоосын үүргээр тохиолдвол өмнөх өгүүлбэрийн санааг давтан үргэлжлүүлэх утгаар холбогдоно. Тухайлбал, Хар ус нуурын шагшуурга намрын салхинд исгэрнэ ... Явуухулангийн алдартай энэ шүлгийн мөрүүд бас л өнгөрснийг санагдуулнам. Хар ус нуурын тухай эхлээд Явуухулан дараа нь Гайтав шүлэг бичиж билээ. Одоо би тэднийхээ мөрөөр Хар ус нуурт ирлээ. Нуурын цэнгэг ус намрын хонгор салхины аясаар мяралзан үеийн хоёр найзыг минь хэзээ нэгэн цагт гаргасан мөртэй эрэг хөвөөгөө илбэж байна. Эх нутгийнхаа нэгэн сайхан усны хөвөөнд гишгэсэн тэдний мөр арилаагүй дээ гэж бодоход яруу сайхан шүлэг дунд нь хэзээ ч арилаагүй мөр болон үргэлжилжээ гэж сэтгэл тэгширнэм. (С.Э., Аян замын бодол буюу уянгын эрих)

Орчин цагийн монгол хэлний дараа хэмээх үг нь үүний/түүний ($N_{\text{pron.}} + N_{\text{gen.}}$) дараа, үүний/түүний ($N_{\text{pron.}} + N_{\text{gen.}}$) дараа-н-аас ($N_{\text{abl.}}$), үүний/түүний дараа-г-аар ($N_{\text{abl.}}$) гэхэд харьяалахын тийн ялгалаар хувилсан э-, тэ- язгууртай заах төлөөний үгэнд туслах үгийн үүргээр орж, өгүүлбэр доторх үг болон дараагийн өгүүлбэрийг өмнөх үг, өгүүлбэртэй холбож байна. Жишээ нь: Үүний дараа бүгд нэгэн элгэн хадны өвөрт сууцгаан Дамдины заавраар толгойгоо бүтээв. (Ч.Л., Алтайд); Түүний дараа хэн нь юун дээр алдсан, хожсоныг ярих хэрэгтэй гэж Бат бодно. (Ч.Л., Тунгалаг Тамир); Түүний дараа Манж их гүрний эзэн хаан их Хуандийг ширээнд залах билээ гэж эхлээд энэ гурван зүйлээ гүйцэтгэхийн тулд юуны өмнө улааны халдварыг үүрэнд нь устгах хэрэгтэй. (Ч.Л., Тунгалаг Тамир); Түүний дараа хөх торгон дээл дээр ногоон бүс бүслээд баруун ташаандаа сэлээдий буу, зүүн ташаандаа хадаг яндар болсон урт сэлэм зүүсэн Түгжил гарч ирлээ (Ч.Л., Тунгалаг Тамир) гэхэд “э-, тэ-” үйл үгээс үүсэлтэй заах төлөөний нэр ба үйл үг нь харьяалахын тийн ялгалаар хувилахад “дараа” гэх үг нь туслах үгийн үүргээр орж хэрвээ өгүүлбэрийн эхэнд байрлавал өмнөх өгүүлбэрийн үйл явдлыг тухайн өгүүлбэртэй холбож өгүүлэх болон бичихэд үйл явдлын хэзээ, хэдүйд болох цагийн дарааллыг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, энэ нь нэг төгс санааг дараагийн төгс санаатай холбож хоёр үйл явдлыг цагийн хугацааны хувьд учир зүйн дараалалд оруулна.

Мөн “эхлээд ... дараа нь” гэж үйл явдлын цаг хугацааны дарааллыг заана. Жишээ нь: Өвгөн дархан эхлээд модон бултай төмөр хигээстэй хоёр том нэг жижиг дугуй хийж давирхайлав. Дараа нь хоёр том дугуйгаа төмөр голоор

холбож хуучин өвсний машины зүрх араа суулгаад жижиг дугуйгаа түүнтэй холбов (С.Э., Диваажинд хүргэх оньс).

Харин яригч сонсогчийн өгүүлэх санааны үйл явдлын цагийн дарааллыг илэрхийлэхэд *daray-ā/darui* хэмээх үг нь цогцолборт холбоосын үүргээр тохиолдвол өмнөх цогцолборын санааг үргэлжлүүлж, дараагийн цогцолборт давтан үргэлжлүүлэх цагийн утгаар орно. Тухайлбал,

а. Эелдэг зөөлөн хаврын өглөө дорно, умар зүгээс том гэгчийн улаан нар сая мандан гараад, баруун Европын нэг ихээхэн хотын чөлөөний эсрэг хандсан нэг өндөр байшингийн гуравдугаар давхрын цонхоор гэгээн гэрэл тусахад, дотор нь унтсан Очирын нүд гялбаж, сая нойрноос сэрэв.

-Даруй босч, хэд суниагаад, гар нүүрээ угааж байтал, санамсаргүй бүдүүн бүрээ ба хэнгэрэг цангийн дуу гадна сонсдов.

-Даруй сонирхол тавин чагнавал, мөнхүү хөгжмийн аялгуу өглөөний ариун агаартай хослон, нээсэн цонхоор орж ирэх нь Очирын сэтгэлд бахтай бөгөөд аятай байдлыг төрүүлнэ. (Д.Н., Майн нэгнийг хөрөнгөтний газар үзжээ.)

б. Хүрэн даавуу дээлийг нарийн дурдан бүсээр бүсэлж, цагаан орос малгай өмссөн зүүн талын соёондоо алтан шүдийг хийсэн хүрээний хөөрхний тоонд орсон, нэг хүүхэн хөдлөх бүр аалигүйгэж, харах бүр “Хи хи хи” гэж нүдээрээ инээнэ.

Дараагаар, чи ингээд, би ингээд, тавгаа цааш нь, шаазангаа нааш нь, энэ хүн нь, тэр юм нь гэлцэн дээгүүрээ түлхэлцэн доогуураа нудралцан, арван таван минутын зуур үргэлж: “Хи хи хи”, “Хи хи хи” гэж инээлдэн байгаад бас л “Хи хи хи”, “Хи хи хи” гэж годолзсоор гарч одов. (Д.Н., Хи хи хи)

Энэ нь хүүрнэн өгүүлэх болон найруулан бичихэд санаагаа оновчтой, учир зүйн дараалалтай илэрхийлэхэд “эхлээд, дараа нь, эцэст нь”, “эхлээд, дараа нь, түүний дараа, тэгээд, эцэст нь”, “эхлээд (толгойд нь, магнайд нь, эхэнд нь), дараа нь, үүний дараа (түүний дараа), эцэст нь (сүүлд нь, төгсгөлд нь) зэрэг үгсийг түгээмэл ашиглаж, заавар, зөвлөгөө өгөхөд тухайн үйлийг хийж гүйцэтгэх алхам, үе шат, хийх дарааллыг тодруулж өгөх болон үйл явдлуудын дарааллыг ирээдүй цагт хүүрнэн өгүүлэх хийгээд цагийн дарааллыг гинжин холбоонд илэрхийлдэг байна. Иймд үйл явдлын дэс дарааллаас гадна цагийн дарааллыг оновчтой тодорхойлох нь хэлний гүн ухааны зүй тогтол болно. Үүнээс үзвэл, ертөнцийн юмс үзэгдлийн зүй тогтлыг хэлээр илэрхийлэхэд үйл явдлын дарааллыг учир зүйтэй орон ба цагийн дараалалтай оновчтой уялдуулах нь *daray-ā* хэмээх цагийн нэрийн утга, үүрэг, хэрэглээг тодорхой болгоно.

Үүнээс дүгнэж үзвэл, хүмүүс өдөр тутам хэлээр харилцах үед юмс үзэгдлийн тухай аман (spoken language) ба бичгийн хэл (written language) -ээр зохистой илэрхийлэх хэрэгцээ гарч байдаг. Иймд хүн мэдээллийг уншиж, эсвэл сонсож хүлээж аваад ойлгож мэдсэн зүйлээ боловсруулж эцэст нь санаагаа ярьж эсвэл бичиж илэрхийлэхэд учир зүйн дарааллыг оновчгүй ашиглавал найруулгын алдаа үүсдэг. Иймд орчин цагийн монгол хэлэнд юмс үзэгдлийн орших орон, хөдлөх зүг

чиг, болох хугацаа, давтамж, учир зүйн зүй тогтлын дэс дарааллыг илэрхийлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг *daɣaɣ-ā* хэмээх үгийн утга, үүрэг, хэрэглээний онцлогийг үгийн сан, хэл зүйн талаас задлан шинжилж нэгтгэн дүгнэв. Иймд цаашид зөвхөн *daɣaɣ-ā* хэмээх үгийн утгыг зөвхөн явцуу хүрээнд судлах бус улмаар өргөн хүрээнд *udaɣ-ā ki*, *qo-ji-m < qo-ji-da*, *qoyin-a*, *segül-dü* (эцэст, төгсгөлд, адагт), *qo-ji-m qoyin-a* (synonym), *urida qo-ji-da* (antonym) зэрэг үгсийн утгатай харьцуулан хэлний макро түвшинд судлах дараагийн судалгааны эхлэл болно гэж үзлээ.

Ном зүй

- Базаррагчаа, М. (2005). *Монгол хэлний өгүүлбэр судлал*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Барайшир, Ш. (1964). *Монгол хэлний байц гишүүн өгүүлбэрийн тухай асуудалд*. МУИС, Эрдэм шинжилгээний бичиг, VII боть, Улаанбаатар: Сүхбаатарын нэрэмжит хэвлэлийн комбинат.
- Жанчивдорж, Ц., Рагчаа, Б. (1967). *Монгол хэлний үг зүй*. Улаанбаатар: Улаанбаатар таймс.
- Лувсанвандан, Ш. (1939). *Монгол хэлний зүй*. Улаанбаатар.
- Лувсанвандан, Ш. (1951). *Монгол хэлний зүй*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.
- Лувсанвандан, Ш. (1968). *Орчин цагийн монгол хэлний бүтэц*, Монгол хэлний үг, нөхцөл хоёр нь. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл.
- Лувсандэндэв, А. (1956). *Монгол хэлний үгсийг аймаглах тухай асуудалд*, Монгол үндэсний хэл бүрэлдэн тогтсон нь. Улаанбаатар.
- Мишиг, Л. (1957). *Монгол хэлний тусалдахуун ба байц*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Монгол хэлний тайлбар толь. (2011) Улаанбаатар: Монсудар хэвлэлийн газар.
- Орчин цагийн монгол хэл (1997). ШУА, ХЗХ, редактор Ц.Цэдэндамба, С.Мөөмөө, Улаанбаатар.
- Орчин цагийн монгол хэлний өгүүлбэр зүй (1989). ШУА, ХЗХ, ред. Ш.Барайшир, Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэл.
- Өнөрбаян, Ц. (2004). *Орчин цагийн монгол хэлний үг зүй*. Улаанбаатар.
- Цэрэнпил, Д., Кулман, Р. (2008). *Монгол хэлний хэл зүй*. Улаанбаатар.
- Бобровников, А. (1835). *Грамматика монгольского языка*. Санктпетербургъ:
- Владимирцов, Б.Я. (1929). *Сравнительная грамматика монгольского письменного языка и халхаского наречия*. Введение и фонетика. Ленинград:
- Ramstedt, G.J. (1935). *Kalmückisches Wörterbuch*. Der Finnischen Literature Gesellschaft. Helsinki:
- Санжеев, Г.Д., Орловская, М.Н., Шевернина, З.В. (2015). *Этимологический словарь монгольских языков*. Том I, А-Е, Москва:
- Тодаева, Б.Х. (1951). *Грамматика современного монгольского языка*. Москва:
- Попов, А.В. (1847). *Грамматика калмыцкого языка*. Казань:
- Poppe, N. (1987). *Introduction to Mongolian Comparative Studies*. Helsinki:

Ашигласан эх хэрэглэгдэхүүн:

- Лодойдамба, Ч. (1951). Алтайд. Улаанбаатар.
- Лодойдамба, Ч. (1971). Тунгалаг Тамир. Улаанбаатар.
- Нацагдорж, Д. (1996). Бүрэн түүвэр. Улаанбаатар.
- Ринчен, Б. (1993). Үүрийн туяа. Улаанбаатар.
- Түдэв, Л. (1985). Оройгүй сүм. Улаанбаатар.

Эрдэнэ, С. (1976). Тууж, өгүүллэгүүд. Улаанбаатар.
Эрдэнэ, С. (1985). Шилмэл өгүүллэг. Улаанбаатар.
<https://dailynews.mn/>

Summary

In this Article, we describe the meaning of the word lexical meaning, grammatical function and usage in Mongolian. For this purpose, we have selected place-time relative noun “daray-ā” from the modern Mongolian, which causes great difficulties for user. There is still much uncertainty in the precise definitions of the word meaning, mainly in making a demarcation between line between the usages of spatial meaning and the temporal meaning, on the one hand, and between the adverb and place-time relative noun, on the other. But the meaning of the word “daray-ā” is used differently in modern Mongolian language. Therefore, the meaning of this word “daray-ā” is explained of the Mongolian language. First meaning of “daray-ā” for Mongolian represent the spatial and temporal meaning. Next meaning explained by frequency and sequence of action. How to use the word “daray-ā” in modern Mongolian language was studied at morphological and syntactic level “daray-ā” mean ‘at a time in the future.